

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР 3 ДУГААР УЛИРАЛД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Гоц халдварт өвчний өнөөгийн байдал

Гоц халдварт бог малын мялзан өвчин Эрдэнэцагаан, Дарьганга сумын 2 голомтод 4 өрхийн 185 толгой мал өвчилж үүнээс үхсэн-37, зориудын устгалд-43, шинж тэмдэг арилсан 105 толгой малыг хяналтандаа авч урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлж байна. Өнөөдрийн байдлаар Дарьганга сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/77 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэм буурч тайван байдалд шилжсэн. Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/133 тоот захирамжаар хорио цээрийн арга хэмжээ, хязгаарлалтын дэглэмд шилжээд байна. Өвчний гаралтын мэдээг өдөр бүр Цагдаа болон Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын талаар

Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх тухай аймгийн Засаг даргын А/464, А/519 тоот захирамжуудыг гарган дархлаажуулалтын ажил хэрэгжиж байна. Үүнд:

- Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2547 өрхийн 777440 хонь, 186922 хурга, нийт 964362 толгой малыг
- Гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 5118 өрхийн 1428600 толгой бог мал дархлаажуулахаас одоогоор 466 өрхийн 428481 толгой мал таригдаж, гүйцэтгэл 30,0 хувьтай байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 7 нэрийн вакцинд 986898 толгой мал хамрагдахаас 763607 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 77,3%-ийн гүйцэтгэлтэй, орон нутгаас малчны гарын үсэг бүхий баримт материалыг үндэслэн 3 дугаар улиралд 91,6 сая төгрөгийн санхүүжилтийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгоод байна.

Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах журмын дагуу халдварт, гоц халдварт өвчний мэдээ болон 3 дугаар улирлын мэдээг нэгтгэн Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлсэн.

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР:

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

Баруун-Урт суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнсний худалдаа эрхэлдэг 10 аж ахуй нэгж, зах худалдааны төвийн 2, өргөтгөсөн худалдаа 1, нийт 13 аж ахуй

нэгж хамрагдаж, 1 зөрчил илрүүлж, 90 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан.

Хяналт шалгалтын явцад гарал үүсэл, шинжилгээ баталгаажилтгүй, сав баглаа боодлын битүүмжлэл алдагдсан 8 нэр төрлийн 23 дээжнээс хүнсний бүтээгдэхүүний дээж авч мал эмнэлгийн лабораторид шинжлүүлэв.



Хүнсний үйлдвэр, худалдааны газруудад урьдчилан сэргийлэх шалгалтаар хадгалах болон хэрэглэх хугацаа дууссан давхардсан тоогоор 13 нэр төрлийн 33 ширхэг 267,0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлж, аж ахуй нэгж дотоод хяналтын журмаа мөрдөж ажиллаагүй зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт зааснаар 1000 нэгжтэй тэнцэх торгуулийн арга хэмжээ авч, хоол хүнсээр дамжих өвчин, хордлого, халдвар гарахаас сэргийлэн ажиллалаа.

Салбарын хяналтын газрын 08-00-03/22 удирдамжийн дагуу хүнсний өндөгний худалдаалалтад Төлөвлөгөөт бус хяналт шалгалтад Баруун-урт, Мөнххаан сумдын 14 аж ахуй нэгж, 1 иргэнийг хамруулан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар нийт 20 зөрчил илрүүлж 75 хувийг газар дээр нь арилгуулж хугацаа шаардах зөрчилд улсын байцаагчийн 1/5 шаардлага хүргүүлэн ажиллалаа.



Иргэнээс Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Улсын ахлах байцаагчид ирсэн муудсан махаар хуушуур хийсэн гомдол мэдээллийн дагуу дээжийг авч мал эмнэлгийн лабораторид шинжлүүлэхэд эерэг хариу гарсан тул дээрх муудсан махны эх үүсвэрийг олж тогтоох хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулан үлдэгдэл махыг лабораторийн шинжилгээнд хамруулахад мөн эерэг хариу гарсан тул 31 кг 299600 мянган төгрөгийн ямааны махыг хураан авч устган мал эмнэлгийн холбогдолтой хууль журам, заавар мөрдөж ажиллаагүй зөрчилд “Зөрчлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.9.2 дахь хэсэгт зааснаар 500 нэгжийн торгуулын арга хэмжээ авч, хоол хүнсээр дамжих өвчин, хордлого, халдвар гарахаас сэргийлэн ажилласан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/197 “мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээний гүйцэтгэлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах тухай”, 2024 оны 01/424 “шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажилд хяналт тавих тухай, Мал эмнэлгийн газрын даргын “мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх тухай” эдгээр удирдамж болон УМЭАЦТЛ-ийн адууны өвчний талаарх шинжилгээний тандалтын ажлаар 13 суманд ажиллав.

Дархлаажуулалтын хяналтын ажлын хүрээнд 21 мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн гоц халдварт болон халдварт өвчний арга хэмжээний гүйцэтгэлийг малчны хотонд хяналтыг хэрэгжүүлэн нийт 110 малчин өрхөөр орж хяналтыг тавьж ажилласан.



Мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагааны хяналтаар төлөвлөгөөнд туссан 6 сумын тасгийг ХХААХҮЯамны сайдын баталсан хяналтын хуудсын дагуу шалгаж үнэлгээг өгч ажиллав.



Адууны 4 төрлийн өвчний тандалтын дээж авах ажилд нийтдээ 13 сумын 65 малчин өрхийн 130 адуунаас ийлдсийн дээж авч цахим системд холбогдох мэдээллийг оруулан ажилласан.



2024 оны УМЭАЦТЛ-ын ийлдсийн тандалтын дүнгээр дээрх сумдын малчин өрхүүдэд бог малын тандалтын дүн эерэг гарсан тул Дарьганга сумын хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг шалгах, сумдын малчин өрхүүдээс асуумж судалгаа, ийлдсийн дээж авахаар ажилласан. Дарьганга суманд хорио цээрийн дэглэм хэрэгжүүлж ажиллаагүй хангалтгүй байсны улмаас сэжигтэй бүсээс шилжилт хөдөлгөөн хийгдсэн зөрчил гарч холбогдох арга хэмжээг авах цаашид дэглэмийг хэрэгжүүлэн ажиллах талаар сумын Засаг даргад үүрэг болгон ажилласан.



Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/254 тоот тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, ерөнхий малын эмчийн 01 албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/354 тоот захирамжийн хүрээнд дараахь ажлыг хийж хэрэгжүүлж байна. Малчид мал бүхий иргэдэд сошиал болон байгууллагын веб сайтаар дамжуулан постер боршурыг хийж олон нийтэд сурталчлан, сумдын тасгуудад ажлыг эрчимжүүлэн, шимэгчтэх өвчний хор хохиролыг таниулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсний ач холбогдол сурталчлах талаар дундын групп, цахим хуудсаар мэдээлэл тогтмол өгч ажиллаж байна.



ХАРИУЦЛАГАТАЙ-МАЛЧИН АЯНЫ ХҮРЭЭНД:

Аймгийн хэмжээнд шимэгчтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 13 сумын 45 ажлын хэсэгт малын эмч-47, санитарч-16, туслах ажилтан-30 нийт 93 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, өнөөдрийн байдлаар 2526737 мал хамрагдахаас 1976800 мал урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдаж 78,2% гүйцэтгэлтэй.

- Угаалга 1197800 мал хамрагдахаас 910000 мал хамрагдаж 75,9%
- Туулгалт 681487 мал хамрагдахаас 498000 мал хамрагдаж 73,0%
- Боловсруулалтад 631300 мал хамрагдахаас 554900 мал хамрагдаж 81,8%
- Үхрийн арьсны гуурын боловсруулалтад 16150 мал хамрагдахаас 13980 мал хамрагдаж 86,3%-ийн гүйцэтгэлтэй тус тус явагдаж байна.

Мөн хашаа хороо, өтөг бууц, худаг уст цэг, тээврийн хэрэгсэл, нийтийн эзэмшлийн талбай зэргийн нийт 3,1 сая м.кв талбайд халдваргүйтгэлийг хийгээд



байна.

Олон нийтийн оролцоонд тулгуурлан зоонозын халдварт өвчнийг эрт мэдээллэх, тандах" төслийн хүрээнд зохион байгуулах сургалтад МАЭМА-ны дарга, халдвартын эмчийн хамт хамрагдаж, мэдээлэл солилцон 13 сумын 32 малчинд зөвлөмж өгч ажилласан.



ОНОШЛОГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

“Намрын ногоон өдрүүд-Сүхбаатарт үйлдвэрлэв 2024” үзэсгэлэн худалдааны цагаан идээ худалдан борлуулж буй иргэд, аж ахуй нэгжийн бүтээгдэхүүнд болон малын гаралтай бүтээгдэхүүнээс дээж авч хяналт тавьж ажилласан. Мөн хээлтүүлэгч хуц, ухна, бух, хээлтэгч үнээ, эм хонь, эм ямаанаас цус авч бруцеллёзын шинжилгээ хийсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар Тархвар зүй мэдээлэл, судалгаа статистикийн газрын дарга Т.Балжинням ахлуулсан ажлын хэсэгт Дарьганга, Эрдэнэцагаан, Түвшинширээ, Мөнххаан, Сүхбаатар сумдаар явж бог малын мялзан өвчний тандалтыг хийж шинжилгээнд дээж авсан.

Үндэсний итгэмжлэлийн төвийн Мөнхбат даргаар ахлуулсан ажлын хэсэг ирж Лабораторийн итгэмжлэлийн техникийн шинжээч О.Аззаяа МЭЛ-д дотоод хяналт шалгалт хийсэн.

Нян судлалын шинжилгээнд:

Цусан халдвар, дотрын халдварт хордлого, булчин цайх, галзуу, дуут хавдар, листериоз зэрэг өвчний давхарсан тоогоор 105 дээжинд шинжилгээ хийж гүйцэтгэсэн байна.


Нян судлалын шинжилгээний бэлтгэл ажилд шаардлагатай МПШ- 52 хуруу шил, тэжээлт орчин – 74 бэлтгэн ариун чанарыг шалгаж хэрэглэж байна.



Ийлдэс судлалын шинжилгээнд:

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/152 тоот тушаал, УМЭАЦТЛ-ийн удирдамжийн дагуу малын гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний тандалт шинжилгээг хийж ажилласан.

Удирдамжинд заасны дагуу сонгогдсон мал сүрэгт бог малын мялзан, шүлхий, БММӨ – ны вакцины өмнөх тандалт шинжилгээнд 10 сумын 30 өрхийн үхэр 4, хонь 6, ямаа 6 нийт 480 толгой малаас цусны дээж цуглуулан элиза урвал тавихад БММӨ – 228 сөрөг, 132 эерэг, халдварлалт нь -36,6%, шүлхий – 457 сөрөг, 23 эерэг 4,8% халдварлалттай гэсэн үр дүн гарсанг баталгаажуулах шинжилгээнд УМЭАЦТЛ-д явуулаад байна.



Мөн адууны ям өвчний шинжилгээг 49 адуунд, сүрьеэ өвчний шинжилгээнд 48 үхрээс дээж авч, боомын шинжилгээнд арьс ширний 105 дээж авч тус тус шинжилгээг хийсэн. Хээлтүүлэгч болон хээлтэгч өвчний шинжилгээнд бух 121, хуц 3044, ухна 1319 нийт 4484 толгой мал хамрагдсан.

Шимэгч судлалын шинжилгээгээр :

Адууны халдварт цус багадах өвчин, адууны Африк мялзан, адууны ям, адууны нийлүүлгийн өвчний тандалтыг Асгат, Баруун-Урт, Мөнххаан, Дарьганга, Халзан, Түвшинширээ, Сүхбаатар, Түмэнцогт, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Наран, Онгон сумын 130 адуунаас дээж авч УМЭАЦТЛ-т хүргүүлээд байна.

Ариун цэврийн шинжилгээнд:

Хүнсний аюулгүй байдал, ариун цэвэр магадлан шинжилгээнд Дарьтшүтээн ХХК-ны Иран улсад экспортонд гаргах үхэр, хонины махнаас дээж авч бета-лактам, сульфонамид, тетрациклиний 3 бүлгийн антибиотикийн үлдэгдлийн шинжилгээг, “Өөдлөх тэнцвэр” “Жанжинтулга” махны худалдан борлуулах захуудад 4 удаа хонь, үхэр, адууны махны 114 дээж авч рН, зэсийн цэнхэрийн урвал, өвчтэй ба үхсэн малын махыг ялган тодорхойлох, 3 бүлгийн антибиотикийн үлдэгдлийг шинжилгээг нийт 127 дээж, антибиотик илрүүлэх шинжилгээ 14 дээжинд хийж ариун цэвэр магадлан шинжилгээний гэрчилгээг олгосон.



Мөн Баялаг өндөгний үйлдвэрийн өндөг худалдан борлуулж өндөг нийлүүлдэг аж ахуй нэгжийн 5600 өндгөнд шалгалт хийж, дээж авч лабораторийн шинжилгээг хийж баталгаажуулсан.



ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР:

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРГАА ӨРГӨЛӨӨ.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 84 дүгээр зарлигаар шинэчлэн батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын дагуу Төрийн захиргааны албан тушаалд хуулийн дагуу томилогдон ажиллаж байгаа 2 сумын МЭТ-н Улсын байцаагч -1, Тархвар зүйч -2, нийт 3 эмч мэргэжилтэн төрийн жинхэнэ албан хаагчийн тангаргаа өргөлөө.

СУЛ ОРОН ТООНЫ ЗАРЫГ ХҮРГҮҮЛЛЭЭ.

Төрийн албаны тухай хуулийн 27.2.т заасны дагуу Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны зарыг хүргүүлж ажилласан ба өнөөдрийн байдлаар МЭГ-т 1, МЭТ-т Улсын байцаагч 2, Тархвар зүйч 7, нийт 11 сул орон тооны зарыг хүргүүлж ажиллалаа.

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДЛАА.



Төрийн албанд үр бүтээлтэй ажиллаж байсан ахмад ажилтнууд болон одоо ажиллаж буй 8 эмчийг /Хөдөлмөрийн хүндэт медаль-1, Алтан гадас-3, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон-2/ Монгол улсын төрийн дээд одон медалиар шагнагдлаа.

ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018) СТАНДАРТЫН ДАГУУ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораториос НҮБ-ын ХХААБ-ын МААЭЗЭН төсөл, УМЭАЦТЛ-ийн "Мал эмнэлгийн сүлжээ лабораториудын чадавхи"-ыг сайжруулах хамтын ажиллагааны хүрээнд ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018) стандартын шаардлага, итгэмжлэл, лабораторийн аюулгүй байдлын дэг мөрдүүлэх, оношилгоо, шинжилгээний илрүүлэх түвшний аргуудыг бататгаж, баталгаажуулах түвшний арга, аргачлалыг заах, шинжлэгч эмч нарыг ажлын байранд дадлагажуулах сургалтанд хамрагдаад байна. Мөн Хэнтий аймагт зохион байгуулагдсан Мал эмнэлгийн ерөнхий газар МААЭЗЭН төсөлтэй хамтран Мал, амьтны гоц халдварт өвчний болзошгүй тохиолдол илэрсэн үед сумын мал эмнэлгийн тасгийн албан хаагчид хэрхэн хууль, дүрэм, заавруудыг дагаж мөрдөж буйг тодорхойлох, цаашид үйл ажиллагаандаа анхаарч, сайжруулах зорилгоор үзүүлэх дадлага, сургалтанд 10 сумын 12 эмч мэргэжилтэн хамрагдаж мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн.





ВАКЦИН ХАДГАЛАХ ХӨРГҮҮР, ЭХО АППАРАТУУД ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Шинэ хөдөө” төслөөс хэрэгжүүлж буй Малын эм, био бэлдмэл, вакцин хадгалах 13 ш хөргүүр, 13ш эхо аппаратыг хүлээн авч 13 суманд хүлээлгэн өглөө. Уг тоног төхөөрөмжийг “Сүвэн-Уул” ХХК тендерт шалгаран нийлүүлсэн.



МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР